УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/43/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453721, Цахим хаяг: ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
3. Аудитын тайлан ........ 12
   3.1 Ерөнхий зүйл ........ 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
   3.4 Материаллаг байдал ........ 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
   3.8 Аудитын гол асуудал ........ 14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
   3.1 Залруулсан алдаа ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.23 № УВА-2022/43/НА-СТА-ТШЗ
танай ______________-ны № ________________-т

АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ
Д.ГАЛБАДРАХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200078

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 10,357,820.00 | 13,435,800.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,357,820.00 | 13,435,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,357,820.00 | 13,435,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,917,800.00 | 10,261,800.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 245,020.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 195,000.00 | 3,174,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | **596,258,293.88** | **602,794,819.37** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 596,258,293.88 | 602,794,819.37 |
| **392** | **Биет хөрөнгө** | 573,308,293.88 | 579,844,819.37 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 434,382,380.00 | 434,382,380.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -21,438,769.68 | -32,158,154.52 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 127,000,000.00 | 127,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,958,333.37 | -50,125,000.05 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 68,826,368.71 | 113,583,062.71 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -26,459,771.37 | -44,873,324.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,062,224.47 | 43,071,727.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,105,804.88 | -11,035,871.52 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **22,950,000.00** | **22,950,000.00** |
| 39301 | Программ хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,950,000.00 | 22,950,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **606,616,113.88** | **616,230,619.37** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | **00.00** | **40,000.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 40,000.00 |
| 413 | **Өглөг** | 00.00 | 40,000.00 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **00.00** | **40,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 40,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | **606,616,113.88** | **616,190,619.37** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 606,616,113.88 | 616,190,619.37 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 190,038,414.75 | 190,038,414.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 190,038,414.75 | 190,038,414.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **186,397,578.85** | **195,972,084.34** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 186,397,578.85 | 186,397,578.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 9,574,505.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 230,180,120.28 | 230,180,120.28 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | **606,616,113.88** | **616,230,619.37** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **454,308,653.43** | **629,217,947.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,959,053.43** | **41,818,847.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,959,053.43** | 41,818,847.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,959,053.43 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,959,053.43 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан /ҮХ/ | | 38,839,847.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан /БМ/ | | 2,979,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **441,349,600.00** | **587,399,100.00** |
| | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **437,349,600.00** | **579,399,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 437,349,600.00 | 579,399,100.00 |
| | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,000,000.00** | **8,000,000.00** |
| ДТ(131103) | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 4,000,000.00 | 8,000,000.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **481,051,578.22** | **619,643,441.51** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **481,051,578.22** | **619,643,441.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **466,563,578.22** | **617,603,441.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **289,171,204.43** | **364,567,909.72** |
| 210101 | Үндсэн цалин | 203,132,638.78 | 243,753,664.38 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 76,627,367.15 | 104,197,811.24 |
| 210203 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,441,198.50 | 13,376,007.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3,240,427.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,234,622.00** | **45,714,340.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,153,823.00 | 31,507,179.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,844,961.00 | 3,610,291.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,380,289.00 | 2,884,933.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 320,320.60 | 701,012.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,535,228.40 | 7,010,924.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,748,767.00** | **22,339,477.80** |
| 210301 | Гэрэл, цахилгааны зардал | 2,011,171.00 | 2,205,693.80 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 16,996,056.00 | 19,424,064.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 741,540.00 | 709,720.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,270,309.00** | **41,097,481.00** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 8,196,750.00 | 11,697,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 7,164,809.00 | 9,143,702.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,623,300.00 | 7,873,879.00 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | 83,250.00 | 2,404,300.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,670,000.00 | 878,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,532,200.00 | 9,100,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,329,040.00** | **18,483,500.00** |

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 27,329,040.00 | 18,483,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,045,000.00** | **2,187,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,045,000.00 | 2,187,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,775,675.00** | **16,090,411.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,030,500.00 | 13,797,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 224,000.00 | 576,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 170,775.00 | 1,186,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 113,900.00 | 23,936.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 00.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 214,500.00 | 214,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **53,740,998.22** | **78,682,101.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,000.00 | 13,422,000.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 2,100,000.00 | 12,158,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 49,340,998.22 | 53,102,101.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,735,962.57** | **30,481,220.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **14,488,000.00** | **2,040,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,428,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,060,000.00 | 2,040,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,247,962.57 | 28,441,220.10 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(26,742,924.79)** | **9,574,505.49** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(26,742,924.79)** | **9,574,505.49** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 441,349,600.00 | **587,399,100.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 00.00 | 00.00 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **441,349,600.00** | **587,399,100.00** |
| | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **437,349,600.00** | **579,399,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 437,349,600.00 | 579,399,100.00 |
| | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,000,000.00** | **8,000,000.00** |
| ДТ(131103) | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 4,000,000.00 | 8,000,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **441,349,600.00** | **566,600,320.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **441,349,600.00** | **566,600,320.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **423,613,637.43** | **536,159,099.90** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **289,357,326.43** | **364,567,909.72** |
| 210101 | Үндсэн цалин | 203,409,639.78 | 243,753,664.38 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 76,536,488.15 | 104,197,811.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,411,198.50 | 13,376,007.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3,240,427.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,048,500.00** | **45,714,340.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,566,400.00 | 31,507,179.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,120,500.00 | 3,610,291.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,496,400.00 | 2,884,933.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 861,407.60 | 701,012.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,003,792.40 | 7,010,924.43 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,748,767.00** | **22,339,477.80** |
| 210301 | Гэрэл, цахилгааны зардал | 2,011,171.00 | 2,205,693.80 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 16,996,056.00 | 19,424,064.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 741,540.00 | 709,720.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **25,130,729.00** | **40,855,961.00** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 8,043,550.00 | 11,701,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 7,409,829.00 | 8,898,682.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,623,300.00 | 7,873,879.00 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | 2,107,450.00 | 2,404,300.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,850,000.00 | 878,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,096,600.00 | 9,100,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,557,640.00** | **18,446,000.00** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,300,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,257,640.00 | 18,446,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,045,000.00** | **2,187,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,045,000.00 | 2,187,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,325,675.00** | **16,090,411.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,580,500.00 | 13,797,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 224,000.00 | 576,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 170,775.00 | 1,186,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 113,900.00 | 23,936.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 00.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 214,500.00 | 214,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,400,000.00** | **25,958,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,000.00 | 13,800,000.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 2,100,000.00 | 12,158,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,735,962.57** | **30,481,220.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **14,488,000.00** | **2,000,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,428,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,060,000.00 | 2,000,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,247,962.57 | 28,441,220.10 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 0.00 | **20,798,780.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | 00.00 | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **20,798,780.00** |
| | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **20,798,780.00** |
| | **Дотоод эх үүсвэрээр** | | **20,798,780.00** |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | **20,798,780.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(20,798,780.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 00.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 01-ээрх үлдэгдэл** | 167,088,414.75 | 00.00 | 98,572,753.79 | 265,661,168.54 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **167,088,414.75** | **00.00** | **98,572,753.79** | **265,661,168.54** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 22,950,000.00 | 00.00 | -42,996,472.84 | -20,046,472.84 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **190,038,414.75** | **230,180,120.28** | **186,397,578.85** | **606,616,113.88** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **190,038,414.75** | **230,180,120.28** | **186,397,578.85** | **606,616,113.88** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **190,038,414.75** | **230,180,120.28** | **186,397,578.85** | **606,616,113.88** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,574,505.49 | 9,574,505.49 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **190,038,414.75** | **230,180,120.28** | **195,972,084.34** | **616,190,619.37** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **579,399,100.00** | **550,957,879.90** | **28,441,220.10** | **95.1%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **579,399,100.00** | **550,957,879.90** | **28,441,220.10** | **95.1%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **577,399,100.00** | **548,957,879.90** | **28,441,220.10** | **95.1%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **387,243,800.00** | **364,567,909.72** | **22,675,890.28** | **94.1%** |
| 210101 | Үндсэн цалин | 249,842,800.00 | 243,753,664.38 | 6,089,135.62 | 97.6% |
| 210102 | Нэмэгдэл цалин | 117,619,500.00 | 104,197,811.24 | 13,421,688.76 | 88.6% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,211,200.00 | 13,376,007.10 | 4,835,192.90 | 73.4% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,570,300.00 | 3,240,427.00 | -1,670,127.00 | 206.4% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,520,300.00** | **45,714,340.38** | **2,805,959.62** | 94.2% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,789,500.00 | 31,507,179.16 | 2,282,320.84 | 93.2% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,682,700.00 | 3,610,291.35 | 72,408.65 | 98.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,946,200.00 | 2,884,933.01 | 61,266.99 | 97.9% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 736,500.00 | 701,012.43 | 35,487.57 | 95.2% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,365,400.00 | 7,010,924.43 | 354,475.57 | 95.2% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,950,000.00** | **22,339,477.80** | **610,522.20** | 97.3% |
| 210301 | Гэрэл, цахилгааны зардал | 2,400,000.00 | 2,205,693.80 | 194,306.20 | 91.9% |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 18,750,000.00 | 19,424,064.00 | -674,064.00 | 103.6% |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,800,000.00 | 709,720.00 | 1,090,280.00 | 39.4% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,856,200.00** | **38,855,961.00** | **239.00** | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 10,575,000.00 | 11,701,100.00 | -1,126,100.00 | 110.6% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,100,000.00 | 8,898,682.00 | -798,682.00 | 109.9% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,672,000.00 | 7,873,879.00 | 1,798,121.00 | 81.4% |
| 210404 | Ном, хэвлэл | 409,200.00 | 404,300.00 | 4,900.00 | 98.8% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 878,000.00 | 122,000.00 | 87.8% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,100,000.00 | 9,100,000.00 | 00.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,446,000.00** | **33,244,780.00** | **201,220.00** | 99.4% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 8,798,780.00 | 201,220.00 | 97.8% |
| 210602 | Тавилга | 7,000,000.00 | 7,000,000.00 | 00.00 | 100% |
| 210604 | Урсгал засвар | 17,446,000.00 | 17,446,000.00 | 00.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,345,000.00** | **2,187,000.00** | **158,000.00** | 93.3% |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,345,000.00 | 2,187,000.00 | 158,000.00 | 93.3% |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **17,946,800.00** | **16,090,411.00** | **1,856,389.00** | **89.7%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,400,000.00 | 13,797,700.00 | 1,602,300.00 | 89.6% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 576,000.00 | 00.00 | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,440,800.00 | 1,186,775.00 | 254,025.00 | 82.4% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 24,000.00 | 23,936.00 | 64.00 | 99.7% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 | 00.00 | 100% |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 247,500.00 | 247,500.00 | 00.00 | 100% |
| 210807 | Газрын төлбөр | 214,500.00 | 214,500.00 | 00.00 | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,091,000.00** | **25,958,000.00** | 133,000.00 | 99.5% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,800,000.00 | 13,800,000.00 | 00.00 | 100% |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 12,291,000.00 | 12,158,000.00 | 133,000.00 | 98.9% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,000,000.00 | 2,000,000.00 | 00.00 | 100% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 2,000,000.00 | 00.00 | 100% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 00.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 579,399,100.00 | 579,399,100.00 | 00.00 | 100% |
| **13** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 579,399,100.00 | 579,399,100.00 | 00.00 | 100% |
| 131001 | Улсын нутгийн төсвөөс | 579,399,100.00 | 579,399,100.00 | 00.00 | 100% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 0.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | | 2,000,000.00 | -2,000,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | | 2,000,000.00 | -2,000,000.00 | |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 6,000,000.00 | -6,000,000.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 5,000,000.00 | -5,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | | 1,000,000.00 | -1,000,000.00 | |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |
| 31 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |
| 131101 | **Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив , тусламж** | | 8,000,000.00 | -8,000,000.00 | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/152 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Прокурорын газар нь "Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 481,051.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,810.5 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 619,643.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,196.4 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,957.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,574.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 10,357.8 | 13,435.8 | 3,077.9 |
| Үндсэн хөрөнгө | 596,258.3 | 602,794.8 | 6,536.5 |
| **Нийт хөрөнгө** | 606,616.1 | 616,190.6 | 9,574.5 |
| Өр төлбөр | 0.00 | 0.04 | 0.04 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 606,616.1 | 616,190.6 | 9,574.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 606,616.1 | 616,230.6 | 9,614.5 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,435.8 мянган төгрөг болж 3,077.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 602,794.8 мянган төгрөг болж 6,536.5 мянган төгрөгөөр өссөн нь 24 нэр төрлийн 38,839.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 18 нэр төрлийн 17,103.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч, тайлант онд 53,102.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 616,190.0 мянган төгрөг болж 9,574.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30,678.1 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 125,250.7 мянган төгрөгөөр буюу 22.1 хувиар өссөн байна. Үүнд хангамж, бараа материалын зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Тайлант онд 0.04 мянган төгрөгийн татварын өр үүссэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Прокурорын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 698,422.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 698,422.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 110,023.8 мянган төгрөгөөр бууруулж 579,399.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 579,399.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 579,399.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 579,399.1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 579,399.1 мянган төгрөгийг зарцуулж, 28,441.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,958.9 мянган төгрөг буюу 95 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 8,000.0 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлжээ.

Үүнээс урсгал засварын зардалд 1,000.0 мянга, ном хэвлэлийн зардалд 2,000.0 мянга, техник, тоног төхөөрөмжийн зардалд 5,000.0 мянга, нийт 8,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Прокурорын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 138, хугацаа хэтрүүлсэн 11, хугацаа болоогүй 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг залрууллаа.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дэх хэсэгт заасныг зөрчин нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас суутгах албан татварын 40.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгэлд тусгаагүй байсныг залрууллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Аймгийн Прокурорын газар | 1 | 40.0 | 1 | 40.0 | | | | | | |
| | **ДҮН** | 1 | 40.0 | 1 | 40.0 | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 20-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ